

## АГУУЛГА

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ .....	3-10
Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, түүний хэрэгжилт	
ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ .....	10-12
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН .....	13-44
Дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд хийсэн ажлын хүрээнд:	
3.1 Захиргааны дотоод ажлын чиглэлээр	
3.2 НЗЗ-ны байруудын инженерийн байгууламжийн ашиглалт, ус дулаан цахилгааны хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр	
3.3 Цэвэрлэгээ үйлчилгээ, эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээний талаар	
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ .....	45-46
ТАВ. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ .....	47-49
ЗУРГАА. ДҮГНЭЛТ .....	50

## НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2018 оныг “Иргэдийн-оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан бодит ажил хэрэг болгоход тайлант оныхоо үйл ажиллагааг чиглүүлэн ажиллалаа.

Одоогийн байдлаар удирдах төрийн захиргааны албан хаагч 1, төрийн үйлчилгээний нийт 288 ажилтан, албан хаагчийн орон тоотойгоор Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, түүний төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлж байна. Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/635 дугаар захирамжийн дагуу Захиргаа, санхүүгийн хэлтэс, Үйлчилгээний алба, Байр ашиглалтын алба гэсэн бүтэцтэйгээр Нийслэлийн Засаг захиргааны 1, 2, 3, 4, 5 дугаар байрууд болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 141 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны “Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр батлах тухай”, 2015 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах тухай” 185 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Нийслэлийн Үйлчилгээний Нэгдсэн төв Дүнжингарав, Мишээл, Драгон, Оргил салбаруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, байр ашиглалтыг хариуцан, мөн Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын хэмжээнд төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө, санхүүг төлөвлөн зарцуулах, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтанд хяналт тавих, ажил үйлчилгээний төсвийг хянах, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх санхүүгийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Мөн Хангарди ордны зоогийн газар, НЗДТГазар, Улаанбаатар чуулгын байруудад байрлах цайны газрууд төрийн албан хаагчдад зориулсан өдөр тутмын зоог болон төрийн томоохон хүлээн авалт, хээрийн зоогийн үйлчилгээг технологийн дагуу үзүүлж байна.

Нийслэлийн Засаг даргын 2018 оны Б/10 дугаар захирамжаар Х.Эрдэнэбилэг нь Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон, Төсвийн Ерөнхийлөн захирагч, Төсвийн шууд захирагчтай 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр үр дүнгийн гэрээг байгуулж, хамтран ажиллахаар гэрээнд гарын үсэг зурлаа.



Зураг 1. Үр дүнгийн гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагаа

## **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ**

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, ажилтан, албан хаагчдад нийтлэг үйлчилгээний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **1. Эдийн засгийн өсөлт-өрх бүрт**

1.4.5 Аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотод соёл урлаг, спорт, олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хүрээнд зохиогдож буй дотоод, гадаад олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцож мөн зохиогдож буй арга хэмжээний үйлчилгээний ажлыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэн ажилласан. Үүнд:

- 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулагдсан “Хараат бус сэтгүүл зүй” үндэсний форумын үйл ажиллагааны үеэр 1000 сэтгүүлчийн цайны завсарлагын үйлчилгээг;
- 2018 оны 06 дугаар сард Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдын санаачилгаар зохион байгуулагдсан Зүүн хойд Азийн бүс нутгийн хотуудын дарга нарын форумын үеэр “Чингисийн хүрээ” аялал жуулчлалын цогцолборт болсон бэсрэг наадмын үйл ажиллагааны үйлчилгээг;
- Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 97 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Төв цэнгэлдэх хүрээлэн болон Хүй 7 худагт 340 орчим зочид, төлөөлөгчдөд 12 нэр төрлийн зоогоор хүндэтгэлийн хүлээн авалтыг;
- 08-р сарын 4, 5-ны өдрүүдэд “Даншиг наадам-Хүрээ цам 2018”-ын үеэр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, түүний зочид төлөөлөгчид болох нийт 120 гаруй хүнд зоогийн үйлчилгээг

тус тус амжилттай зохион байгуулан ажилласан.

### **3. Байгаль орчин, ногоон хөгжил**

#### **3.3 Хот тохижилт, ногоон байгууламж**

Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил”-ийн хүрээнд тус газар нь 2018 оныг “Төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах” жил болгон зарласан. Энэ хүрээнд “Эрүүл тохилог ажлын байр” 1 сарын хугацаатай болзолт уралдааныг зарлаж, НЗЗ-ны 1, 2, 3, 4, 5 дугаар байрууд, НҮНТ-ийн Дүнжингарав, Драгон, Мишээл салбаруудын гадна орчинд тохижилт, зүлэгжүүлэлт, суулгац суулгах ажлууд хийгдсэн. Ингэснээр төрийн албан хаагчдад амрах, ая тухтай орчин бүрдсэн.

### **4. Нийгмийн хөгжил**

#### **4.2 Эрүүл мэнд**

4.2.6 "Эрүүл залуус" аян хэрэгжүүлж, залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгон, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна.

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 15-аас 64 насны хүн амын бие бялдарын хөгжилт, чийрэгжилтийн төвшинг тогтоох сорилыг 05 дугаар сард авсан бөгөөд ажилтан, албан хаагчдын 208 буюу 91.25% бүрэн хамрагдаж, 48 буюу 18.75% нь хүндэтгэх шалтгааны улмаас хамрагдаагүй.



Зураг 2. Бие бялдарын сорилын үеэр

- Нийтлэг үйлчилгээний газар нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэн жил тутам эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулан ажиллаж ирсэн. 2018 оны 04 дүгээр сарын 27, 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран хавдраас урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулж, нийт 191 ажилтан, албан хаагч хамрагдсан.



Зураг 3. НҮГ-ын даргын тушаал, ХСҮТ-тэй хамтран ажиллах гэрээ

- Эрүүл зөв хооллолт, амьдралын зөв дадал хэвшлийг сурталчилах зорилгоор эрүүл мэндийн өдөрлөгийг Хан-Уул дүүргийн ЭМН-тэй хамтран зохион байгуулж, чихрийн шижинг тодорхойлох үзлэг, цусны даралт ихсэх шалтгаан, зөв хооллолтын талаарх мэргэжлийн зөвлөгөөг өгч ажилласан. Уг өдөрлөгийн арга хэмжээнд манай байгууллагаас гадна НЗДТГ-ын нийт 80 ажилтан, албан хаагчид хамрагдсан бөгөөд эдгээр хүмүүсийн халдварын бус өвчлөл тусах

эрсдлийг үнэлэх, антропометрийн хэмжилт хийн, биеийн жингийн индекс тооцох, цусны даралт хэмжих, биохимийн шинжилгээгээр цусан дахь тос, сахар зэргийг тодорхойллоо.



Зураг 4. Эрүүл мэндийн өдөрлөгийн үеэр

- Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд болон дүүргүүдийн ЗДТГ-аас сүүлийн гурван жилийн хугацаанд “Эрүүл ажлын байр” удирдамжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд байгууллага, хамт олныхоо дунд эрүүл амьдрах хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, ажилчдын эрүүл мэндийг дэмжих орчинг бий болгоход идэвх санаачлагатай ажиллаж, бусдыгаа манлайлсан байгууллагуудыг шалгарууллаа. Тасралтгүй нэмэгдэж буй халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, эрт илрүүлгийг нэмэгдүүлэх, өвчлөл болон түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах нь “Эрүүл ажлын байр” удирдамжийн гол үзүүлэлт юм. Уг удирдамжийн шалгуур үзүүлэлтийг ханган ажиллаж “ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР”-ыг бүрдүүлсэн шилдэг байгууллагаар 2-р байрт шалгарсан.



Зураг 5. Эрүүл ажлын байр бүрдүүлсэн шилдэг байгууллагуудын шагнал гардуулах ажиллагаанд

#### 4.4 Нийтийн биеийн тамир, спорт

4.4.3 “Улаанбаатар Марафон” олон улсын гүйлтийн тэмцээн, Нийслэлийн иргэдийн спортын наадмыг олон төрлөөр жил бүр өргөн хүрээнд зохион байгуулах ажлын хүрээнд:

“Улаанбаатар Марафон - 2018” олон улсын гүйлтийг зохион байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын А/147 дугаар захирамжийн хүрээнд “Улаанбаатар марафонд нэгдэцгээе” уриан дор аяны цомыг Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв ОНӨУҮГ-аас хүлээн авч, Нийслэлийн Мэдээлэл технологийн газрын биеийн тамир спортын хамтлагт шилжүүлэн өгсөн.

НЗД-ын захирамжийн дагуу 2018 оны 05 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан “Улаанбаатар Марафон-2018” олон улсын гүйлтийн тэмцээнд Нийтлэг үйлчилгээний газрын 82 ажилтан, албан хаагч идэвхтэй оролцсон.



Зураг 6. “Улаанбаатар Марафон”-ы үер

4.4.4 Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмыг жил бүр зохион байгуулах ажлын хүрээнд:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2018 оны зорилтыг хэрэгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд Нийслэлийн төр захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдыг болон иргэдийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, амралт чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зохилгоор “Мөнгөн Улаанбаатар” өвлийн спорт наадмын хүрээнд нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд цасны баярын үйл ажиллагааг 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Хандгайтын “Янзага” зусланд зохион байгуулсан. Цасны баярын гол ажиллагаа болох галт бамбар асаах өртөөчилсөн буухиад нийслэл, дүүргийн шилдэг биеийн тамир, спортын хамтлагийн төлөөл оролцож үүнд манай байгууллагын БТС-ын хамтлагийн гишүүн Т.Шашиймаа бамбарыг асаалцах ажиллагаанд амжилттай оролцов.



Зураг 7. “Мөнгөн Улаанбаатар” өвлийн наадмын нээлтийн үйл ажиллагаа

Уг арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын дунд 2017 онд биеийн тамир, спортын үйл ажиллагаагаараа тэргүүлсэн хамтлагийг шалгаруулж, манай байгууллагын БТС хамтлаг нь “Шилдэг хамтлаг”-ийн 2-р байранд шалгарч цом, мөнгөн шагналыг гардан авлаа. Нийтлэг үйлчилгээний БТС-ын хамтлаг нь 4 жил дараалан энэхүү хүндтэй шилдэг гэсэн нэрийг зүүж амжилттай ажиллаж байна.



Зураг 8. БТС-ын шилдэг хамтлагийн цом гардан авсан агшин

4.4.5 Идэвхитэй хөдөлгөөнд суурилсан явган болон дугуйн аялал, алхалт, гүйлт, иог фитнесээр хичээллэх иргэдийн орчин нөхцлийг бүрдүүлж, бодлогоор дэмжинэ.

- Нийтлэг үйлчилгээний газар нь байгууллагын ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор БТСХамтлагтай хамтран 2018 оны 10 сарын 13-ны бямба гаригт спорт явган аялалыг зохион байгууллаа. Явган аялал Чингэлтэйн автобусны эцсийн буудлаас Чингэлтэй хайрхан уулын оргил хүртэл гэсэн маршрутаар эхэлж ирэх, очих нийт 6 км замд амжилттай алхалаа.



Зураг 9. Явган аялалын үеэр

- НҮГ-аас зохион байгуулсан “Эрүүл, тохилог ажлын байр” болзолт уралдааны хүрээнд НЗЗ-ны 1, 4 дүгээр байрны үйлчилгээний ажилчид тухайн байранд үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын дэмжлэгтэйгээр төрийн албан хаагчдын амралтын цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх зорилгоор чийрэгжүүлэлтийн өрөөг өөрсдийн хүчээр шинээр тохижуулсан.



Зураг 10. НЗЗ-ны 4 дүгээр байран дахь чийрэгжүүлэлтийн өрөө

#### **4.5 Хүүхэд, гэр бүлийн хөгжил**

##### **“Хүүхдэд ээлтэй Улаанбаатар” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд:**

Нийтлэг үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдын гэр бүл, үр хүүхдийг боловсролтой, амьдрах ухаантай иргэн болгон төлөвшүүлэхэд байгууллагын зүгээс хувь нэмэр оруулах үүднээс БНХАУ-ын 10 топ дээд сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт байгууллагын албан хаагчид болон 9 ажилтны 9 хүүхдийг хэлний мэдлэгийн түвшинг тогтоох шалгалтанд хамруулсан. Шалгалтын хариугаар архив, бичиг хэргийн ажилтан Б.Нарантуул шалгалтанд тэнцэж, шаардлагатай баримт, бичгийг хүргүүлж, хариуг хүлээж байна. Мөн тус улсад дипломын мэргэжил олгох 3 жилийн тэтгэлэгт сургалтанд үйлчлэгч П.Батхишигийн хүүхдийг хамруулан бүртгүүлсэн. Уг хөтөлбөрийн сургалт нь программистын чиглэлээр 3 жил сургалт, байрны төлбөргүйгээр сурахын зэрэгцээ, сард 1000 юанын цалинтай суралцах нөхцөлтэй хөтөлбөр юм. Мөн Нийслэлийн Залуучууд хөгжлийн газартай хамтран ажиллаж компьютерийн анхан шатны болон фото шоп программын сертификаттай сургалтанд ажилчдын 15 хүүхдийг хамруулсан.

#### **4.8 Нийгмийн халамж**

4.8.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох боломжийг бүрдүүлэхэд барилга байгууламж, зам талбайн орчинд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтэцийн стандартыг хангуулах ажлын хүрээнд:

НЗЗ-ны байрууд, НҮНТ-үүдийн байрны орчин, зам талбайг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтэцийн стандартыг хангаж үйлчилүүлэхэд саадгүй байх нөхцөлийг бүрдүүлэн бий болгосон.





Зураг 11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарц

## 5. Засаглал

### 5.1 Оновчтой бүтэц, уялдаатай үйлчилгээ, хариуцлагатай албан хаагч

5.1.2 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүнг “Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” /KPI/-ээр үнэлж, хүний нөөцийн бүртгэл хяналтын удирдлагын нэгдсэн санг бий болгох ажлын хүрээнд:

Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг /KPI/-ээр үнэлэх шалгуур үзүүлэлтийг дүрмээр хүлээсэн үндсэн 3 чиг үүргийн хүрээнд нийцүүлэн тодорхойлж, шалгуур үзүүлэлтийг тооцоолох томъёолол, загварчлалыг гаргаж 2017, 2018 оны үйл ажиллагааны үнэлгээг үнэлсэн. Бидний гаргасан томъёоллоос үнэлгээг харьцуулж харахад 2018 онд үнэлгээ өссөн харагдаж байгаа хэдий ч шалгуур үзүүлэлтийг тооцоолох томъёо, аргачлалыг дахин нягтлах, мэргэжлийн байгууллагаас арга зүйн зөвлөгөө авч ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

5.1.6 “Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр” хэрэгжүүлж, авлигаас ангид төрийн албыг бэхжүүлсэн тунгалаг хот болох ажлын хүрээнд:

Улсын их хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/237 дугаар захирамжийн хүрээнд тайлант хугацаанд байгууллагын захиргаа, санхүүгийн хэлтсийн давхардсан тоогоор 48 албан хаагчийг авилгатай тэмцэх газраас зохин байгуулсан нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулсан.

5.1.9 Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

Нийтлэг үйлчилгээний газар нь Хүний нөөцийн хөгжлийн 2018-2020 оны хөтөлбөрийг боловсруулан баталж, тус хөтөлбөрийн хүрээнд тухайн жилийн сургалт, эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг гарган ажилласан. Энэ хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан. Үүнд:

- Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор нийт ажилтан, албан хаагчдын дунд мэдээллийн цагийг 5 удаа, сургалтыг 19 удаа зохион байгуулсан.

- Үйлчилгээний 35 ажилтанг Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын мэргэжил олгох сургалтанд хамруулж, түүнээс 33 нь мэргэжлийн үнэмлэхээ гардан авсан.
- Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх тогтвор суурьшлыг хангах үүднээс ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 90 ажилтанд түлшний хөнгөлөлт үзүүлсэн.
- Лифтчин С.Одончимэг, үйлчлэгч Б.Энхчимэг нарын түрээсийн орон сууцанд орох хүсэлтийн дагуу байгууллагаас шаардлагатай бүхий л талаар дэмжлэг үзүүлж амьдрах нөхцлийг нь сайжруулж орон сууцтай болгосон.

5.3.11 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлэх ажлын хүрээнд:

Төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө санхүүг төлөвлөн зарцуулж, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтанд хяналт тавин, ажил үйлчилгээний төсвийг хянан, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж, төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн 2018 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, хугацаанд нь НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн татварын газарт хүргүүлсэн. Шилэн данс, вэб сайтад 3 төрлийн тайланг хугацаанд нь сар бүр байршуулан ажилласан.

## ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2.1 Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд:

Нийтлэг Үйлчилгээний газрын үндсэн чиг үүрэг нь төрийн албан хаагчийн ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлж, эрүүл аюулгүй ажлын байрны бүрдлийг хангахад оршино. Тус газар үйл ажиллагаандаа дараах захирамжлалын баримт бичгийн холбогдох заалтын дагуу тайлан мэдээг гаргаж ажилласан. Үүнд:

Хүснэгт 1

Д/д	Захирамжлалын баримт бичгийн төрөл	Захирамжлалын баримт бичгийн тухай	Хамаарах зүйл заалт
1	Улсын Их Хурлын тогтоол	1. “Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” /№2016-51/	2
2	Засгийн газрын тогтоол	2. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт - шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлах тухай /№2017-89/	2, 3
		3. 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай /№2018-32/	2.1 - 2.5, 4

		4. Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай /№2018-258/	1.1 - 1.4, 1.7, 1.9, 1.10, 3
3	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	5. 2018.04.04-ний өдрийн 16 дугаар тэмдэглэл	2
4	Засгийн газрын албан даалгавар	6. Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай /№2017-01/	1.1-1.4, 2.1 - 2.5, 4, 5
		7. Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай /2018-01/	2.1.1, 2.1.2
5	НИТХ-ын тогтоол	-	-
6	НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол	8. “Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам” батлах тухай /№2017-90/	1, 2.3
		9. Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг ханган чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай /№2018-11/	1.3.1, 1.3.5, 2.2.2
Нийт		9	35

НЗД-ын захирамж, НЗД-ын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, НЗД-ын албан даалгаврын хэрэгжилтийн тайлан мэдээг сарын бүрийн 05-ны өдрийн дотор дараах байдлаар гаргаж, НЗДТГ-ын ХШҮХ-т цахим суурьтайгаар хүргүүлэн ажиллаж байна:

Хүснэгт 2

Д/д	Захирамжлалын баримт бичгийн төрөл	Захирамжлалын баримт бичгийн тухай	Хамаарах зүйл заалт
1	Нийслэлийн Засаг даргын захирамж	1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам батлах тухай /№2017-А/335/	1
		2. 2018 оныг “Иргэдийн оролцоотой – Амьдрах орчныг сайжруулах жил” болгон зарлах тухай /№2018-А/01/	1
		3. Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай /№2018-А43/	1.1 /6/
		4. Нийслэлийн засаг захиргааны байруудын засварын ажлын эрх шилжүүлэх тухай /№2018-А142/	2, 3
		5. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг	3

		хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай /№2018-А/237/	
		6. Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай /№2018-А/305/	1, 2, 3
		7. Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай /№2018-А/333/	1
		8. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай /№2018-363/	2
		9. Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай /№2018-А509/	2
		10. Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай /№2018-А/968/	1
2	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл	11. Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын 2017 оны шийдвэрлэлтийн байдал, цаашид анхаарах асуудлын тухай /№2018-А/02/	1
		12. Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын 2018 оны 01 дүгээр улирлын шийдвэрлэлтийн байдал, цаашид анхаарах асуудлын тухай /№2018-11/	1
3	Нийслэлийн Засаг даргын албан даалгавар	13. Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай /№2017/	1
		14. Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай /№2018-03/	1.1 – 1.6, 2
	Нийт	14	28

2.2 Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх ажлын хүрээнд:

Газрын даргын зүгээс байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилттэй холбогдох “А” дугаартай 64 тушаал, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой “Б” дугаартай 478 тушаал батлагдсан байна. Эдгээр тушаалыг НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 90 дүгээр тогтоолын дагуу Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан [www.ublegal.mn](http://www.ublegal.mn) сайтад тухай бүр байршуулан ажиллаж байна.

## ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Дүрмээр хүлээсэн үүргийн хүрээнд:

### 3.1 Захиргаа, дотоод ажлын чиглэлээр

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээг шинэ шатанд гаргаж, шийдвэр гаргах түвшинд иргэд, оршин суугчдын саналыг тусган хотын хөгжил, бүтээн байгуулалт, тохижилтын ажилд тэдний оролцоог нэмэгдүүлэх, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангах зорилгоор 2018 оныг “Иргэдийн оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил” болгосонтой холбогдуулан НҮГазар нь “Төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах жил” болгон зарлаж үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж Нийслэлийн засаг захиргааны байруудын тохижилтын чиглэлээр үйлчилгээ, техникийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, шинэ санал санаачилгыг дэмжих, идэвхижүүлэн урамшуулах зорилгоор “Эрүүл тохилог ажлын байр” сэдэвт 1 сарын хугацаатай болзолт уралдааныг зарлан явуулсан. Уралдаанд нийт 17 баг оролцсон ба багуудын ажлын тайланг ажлын хэсгийн гишүүд үнэлж, 1, 2, 3, 4, 5 байрыг шалгаруулан, шагнаж урамшууллаа.



Зураг 12. Болзолт уралдаанд тэргүүлсэн багууд

#### 3.1.1 Хүний нөөцийн талаар:

2018 онд байгууллагын удирдлага солигдсонтой холбогдуулан хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн дотоод журманд нэмэлт өөрчлөлт оруулж бүх ажилтан, албан хаагчдад танилцуулан, шинэчилсэн хөдөлмөрийн гэрээг захиргаа, санхүүгийн хэлтсийн 44 албан хаагч, байр ашиглалтын албаны 42 ажилтан, 172 үйлчилгээний албаны ажилтантай байгуулсан.

НҮГ-т одоогийн байдлаар мэргэшсэн нягтлан бодогч 2, ахлах зэрэгтэй эмч 1, 1-3 дугаар зэрэгтэй тогооч 12 тус тус ажиллаж байгаа бөгөөд 2018 оны 12-р сарын байдлаар 289 ажилтан, албан хаагчдын 80 хувь нь 3 болон түүнээс дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Байгууллагад хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгууллагын [www.khangardi.mn](http://www.khangardi.mn) вэб, цахим сүлжээ [www.unegui.mn](http://www.unegui.mn) сайт болон Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд ажлын байрны захиалга өгч сул орон тоог нээлттэй зарлаж хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг ханган ажиллаж байна. Дүүргүүдийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдээс ирүүлсэн зуучлалын мэдэгдэл, сайтын 27 удаагийн зараар 136 хүн материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн ба анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж, ажлаас чөлөөлөгдсөн 64, жирэмсэний амралттай 12, тэтгэвэрт гарсан 5, урт хугацааны чөлөөтэй 5 хүний оронд нийт 86 хүнийг шинээр ажилд томилсон. Шинээр ажилд орж байгаа ажилтнуудад газрын хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, ажлын байрны онцлог, цалингийн сүлжээ, хөдөлмөрийн гэрээг танилцуулж, санал авах хуудас, шинээр ажилд орж байгаа ажилтнуудын танилцуулгын хуудсыг хийж холбогдох албан тушаалтнуудаас санал авч тушаал шийдвэрийг гаргаж тухайн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилласан.

НҮГ-ын ажилтан, албан хаагчдаас Удирдлагын академийн пүрэв гарагийн ангид 1, Роял академийн магистрын ангид 1, МҮИС-н магистрын ангид 1, Мандах дээд сургуулийн магистрын ангид 1, нийт 4 ажилтан, албан хаагч тус тус суралцаж, мэдлэг боловсролоо дээшлүүлж байна.

Тайлант хугацаанд Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын мэргэжил олгох сертификаттай сургалтанд 35 үйлчлэгч, Нийслэлийн Залуучууд хөгжлийн газрын дэргэдэх М.К.И.Т сургалтын төвд компьютерийн анхан шатны сертификаттай сургалтанд 31 ажилтан, албан хаагч, тэдгээрийн ар гэр, үр хүүхэд тус тус хамрагдсан.

Мөн Хүний нөөцийг чадавхижуулах ажлын хүрээнд 2018 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр “Хувь хүний хөгжил” сэдэвт сургалтыг захиргааны албан хаагчид болон үйлчилгээ, техникийн ажилтнуудад 2 удаа зохион байгуулсан бөгөөд Азийн сан, КОИСА Олон улсын байгууллагын хамтарсан “Эерэг хандлага, ажлын байран дахь харилцааны сэтгэл зүй”, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр “Бүтээгдэхүүний инноваци ба ажил амьдралын баланс” сэдэвт 2 удаагийн сургалтад захиргаа, санхүүгийн хэлтсээс 45, үйлчилгээний албанаас 15, байр ашиглалтын албанаас 15, нийт 75 ажилтан, албан хаагч, 2018 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан менежерүүдийн сургалтанд 10 менежер, Монголын Нийтлэг үйлчилгээ эрхлэх мэргэжлийн холбооноос зохион байгуулсан “Угтах үйлчилгээний стандарт” сургалтанд 2 угтах үйлчилгээний ажилтан тус тус хамрагдсан.





*Зураг 13. Зохион байгуулагдсан сургалтуудын үеэр*

2018 оны байдлаар нийт 5 удаагийн мэдээллийн цагаар 6 багш урьж нийт албан хаагчдад мэдээлэл хүргэж ажиллалаа. НҮГ-ын ажилтан, албан хаагчдын мэдээллийн цагаар Улсын мөрдөн байцаах газрын мөрдөх албаны дүн шинжилгээ хяналт хариуцсан чиглэлийн ахлах мөрдөн байцаагч дэд хурандаа Э.Нэмэхжаргал "Хариуцлага, сахилга бат, ёс зүй" сэдвээр мэдээлэл хийлээ. Тус мэдээлэлээр шинээр мөрдөгдөж буй хууль дүрэм, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, хувь хүний хариуцлага, сахилга бат, ёс зүйн талаар зөвлөгөө мэдээлэл өглөө.



*Зураг 14. "Хариуцлага, сахилга бат, ёс зүй" сэдэвт мэдээллийн үеэр*

НҮГ-ын ээлжит мэдээллийн цагийг 2018 оны 05 сарын 29 өдөр зохион байгуулсан бөгөөд тус мэдээллийн цагаар "Аз жаргалтай хот хөтөлбөрийн тухай танилцуулга"-ыг НЗДТГ-ын мэргэжилтэн Р.Ягаанцэцэг, "Улаанбаатар банкны

бүтээгдэхүүн үйлчилгээ”-ний талаар Улаанбаатар банкны зээлийн эдийн засагч П.Лхагвабуд нар тус тус мэдээлэл өгч албан хаагчдын сонирхсон асуултанд хариулт өглөө.



*Зураг 15. Мэдээллийн цагийн үеэр*

2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр “Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, зөв амьдралын дадал зуршил” сэдвээр Шинжлэх ухаан биологийн хүрээлэнгийн доктор Ч.Чулуунсүх зөв хооллохын мөн идэвхитэй дасгал хөдөлгөөн хийхийн ач тусын талаар энгийн ойлгомжтой хэлбэрээр сонирхолтой мэдээллийг тус тус хийлээ.



*Зураг 16. “Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, зөв амьдралын дадал зуршил” сэдэвт мэдээллийн үеэр*

12 дугаар сарын 07-ны өдөр “Мэргэжлийн ёс зүй” сэдвээр НЗДТГ-ын мэргэжилтэн Т.Бат-Оргил НҮГ-ын ажилтан албан хаагчдад ёс зүй гэж юу болох, мэргэжлийн ёс зүйн ач холбогдол, сүүлийн үед мөрдөгдөж буй хууль дүрэм, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл хийлээ. Мөн энэ өдөр НМХГ-ын ахлах байцаагч н.Эрхэмбаяр “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй” сэдвээр



мэдээлэл хийхээс гадна тохиолдолж болзошгүй аюул осол, эрсдлээс сэргийлэх талаар анхааруулга зөвлөгөө өгсөн нь хамт олонд сонирхолтой хэрэгтэй мэдээлэл байлаа.



Зураг 17. Ээлжит мэдээллийн цагийн үеэр

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтанд захиргаа, санхүүгийн хэлтсийн 48 албан хаагч хамрагдсан.

### 3.1.2 Тушаал шийдвэрийн талаар:

Газрын даргаас нийт 542 тушаал батлагдан гарснаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал 64, хүний нөөцтэй холбогдолтой Б тушаал 478 батлагдан гарсан байна.




График 1. Тушаалын ангилал

### 3.1.3 Өргөдөл гомдолын талаар:

Газрын хэмжээнд тайлант хугацаанд нийт 230 хүсэлт ирснийг “Өргөдөл гомдлын нэгдсэн программ”-д бүртгэж, хуулийн хугацаанд 230 хүсэлтийг шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн. Мөн хугацаанд өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг сүүлийн 3 жилээр харьцуулхад 2016 онд 4 хоног 10 цаг 19 минут, 2017 онд 6 хоног 0 цаг 32 минут, 2018 онд 4 хоног 11 цаг 41 минут болж өмнөх оныхоос 25,5%-иар буурсан эерэг үзүүлэлттэй ажиллалаа.



График 2. Өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн хугацаа

Үүнээс байгууллагаас тусламж, тэтгэмж хүссэн 29 өргөдлийг 100 хувь шийдвэрлэж, орон байрны асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүссэн 3 өргөдөл ирснийг тус байгууллагын ажилтан албан хаагчдын энэ чиглэлийн өргөдлийг бүртгэх бүртгэлийг бий болгож холбогдох байгууллагуудад уламжилсан.

Ирсэн өргөдлийг ангилан авч үзвэл:

- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой - 35
- Захиргааны чөлөө хүссэн - 55
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой - 71
- Ажилд шилжин ажиллахтай холбоотой - 11
- Жирэмсний болон ээлжийн амралт хүссэн - 22
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай - 30
- Бусад асуудлаар – 7



График 3. Өргөдлийн төрөл

### 3.1.4 Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд нийслэлийн засаг даргын 2017 оны А/252 дугаар захирамж “Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, газрын даргын 2015 оны

A/64 дүгээр тушаалаар батлуулсан “Байгууллагын архивын дүрэм”-ийг тус тус мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын БНШК-ыг газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн A/24 тушаалаар шинэчилэн байгуулж, 2018 онд 98 хадгаламжийн нэгж бүхий ХХНЖ-ыг батлуулсан. Байгууллагад хөтлөгдөх 98 хэргээс:

- Байнга хадгалах хэргийн тоо 44
- Түр хадгалах хэргийн тоо 49
- 70 жил хадгалах хэргийн тоо 5 тус тус байхаар батлуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Захирамжлалын баримтад цахим хувь үйлдэх тухай” A/452 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2015 оны "Архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын нийтлэг журмыг батлах тухай" A/177 дугаар захирамжийн хэрэгжилтийн дагуу байгууллагын 2018 оны газрын даргын тушаал шийдвэрийг 100 хувь Нийслэлийн Архивын газрын цахим апплэйкшнд оруулан хадгалсан.

Тайлант хугацаанд ирсэн бичиг 479, явсан бичиг 679 байгаа бөгөөд 2018 онд ирсэн албан бичгийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3

№	Төрөл	Ирсэн бичгийн нийт тоо	Шийдвэрлэлт				
			Хариутай бичиг	Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь	Хариугүй бичиг	Хариугүй бичгийн хаалтын хувь	Нийт ирсэн бичгийн Шийдвэрлэлтийн хувь
1.	Нийт ирсэн бичиг	479	121	98,69%	358	99,52%	99,10%

Тайлант хугацаанд явсан албан бичгийг хүснэгтээр ангилан харуулбал:

Хүснэгт 4

№	Төрөл	Явсан бичгийн нийт тоо	Шийдвэрлэлт					
			Хариутай бичиг	Хариугүй бичиг	Хуулинд заагдсан хугацаанд шийдвэрлэсэн	Шийдвэрлэлтийн шатанд байгаа бичиг	Хугацаа хэтэрсэн бичиг	Шийдвэрлэлтийн хувь
1.	Нийт явсан бичиг	679	4	675	0	0	4	91,67%

### 3.1.5 Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Ур чадвар, шагнал урамшууллын талаар:

Газрын даргын 2018 оны А/17 дугаар тушаалаар баталсан “Ур чадварын нэмэгдэл олгох, дүгнэх журам”-ын дагуу байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлыг улирал бүр дүгнэн ур чадварын нэмэгдлийг 10-25 хүртэл хувиар олгож, тогтвор суурьшил, идэвх санаачилга, үр бүтээлтэй ажилласан албан хаагчдад хагас, бүтэн жилээр үр дүнгийн урамшуулал олгон ажиллав.

2018 оны 3, 4-р улиралд ажилтан, албан хаагчдын ажлын тогтвор суурьшил, нийгмийн баталгааг хангах үүднээс гэр хороололд амьдардаг 90 ажилтанд түлшний хөнгөлөлтөнд 18 000 000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.

Байгууллагын ажилтан, албан хаагчдын ар гэрт гачигдал тохиолдсон үед хөдөлмөрийн дотоод журмын дагуу газрын даргын тушаалаар 14 000 000 төгрөгийг зарцуулсан.

Мөн 2018 онд байгууллага ажилтан, албан хаагчдынхаа хөдөлмөрийг өндрөөр үнэлж:

- Төрийн дээд шагнал - 2
- Засгийн газрын шагнал – 7
- ТЗҮЭГ-ын “Хүндэт жуух” - 2
- Монголын Залуучуудын Холбооны шагналаар - 5
- НИТХ-ын шагналаар - 6
- Нийслэлийн Засаг даргын шагналаар – 28
- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн “Өргөмжлөл” – 2
- НҮГ-ын 2018 оны “Хөдөлмөрийн аварга” – 3
- НҮГ-ын “Шилдэг ажилтан” - 4
- Бусад байгууллагуудын шагналаар -13

нийт 72 ажилтан, албан хаагчид тус тус шагнагдсан.

### 3.1.6 Эрүүл мэндийн талаар:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 15-аас 64 насны хүн амын бие бялдарын хөгжилт, чийрэгжилтийн төвшинг тогтоох сорилыг 05 дугаар сард авсан бөгөөд ажилтан, албан хаагчдын 208 буюу 91.25% бүрэн хамрагдаж, 48 буюу 18.75% нь хүндэтгэх шалтгааны улмаас хамрагдаагүй.



Зураг 18. Бие бялдарын хөгжилт, чийрэгжилтийн төвшинг тогтоох сорил

Нийт албан хаагчдын дунд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд 1 удаа байгууллагаас үнэ төлбөрийг даан хийдэг уламжлалтай бөгөөд 2018 оны хувьд Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран хавдрын нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд 191 албан хаагчдыг хамруулж, газрын даргын 2018 оны А/29 дүгээр тушаалаар баталсан урьдчилан сэргийлэх үзлэгийн багцын төлбөрт 16 250 000 төгрөгийг зарцуулсан.



Зураг 19. Урьдчилан сэргийлэх үзлэгийн үеэр

### 3.1.7 Биеийн тамир спортын талаар:

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Улаанбаатар Марафон-2018” олон улсын гүйлтийн тэмцээн 2018 онд тав дахь жилдээ зохион байгуулагдлаа. Энэхүү үйл ажиллагаанд Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын 82 ажилтан албан хаагчид идэвхтэй оролцон 5 км зайд гүйлээ



Зураг 20. “Улаанбаатар Марафон”-ы үеэр

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газрын даргын 2018 оны А/30 дугаар тушаалаар баталсан байгууллагын аварга шалгаруулах спортын тэмцээн зохион байгуулах удирдамжийн дагуу Нийтлэг үйлчилгээний газрын БТСХамтлаг нь 2018 оны биеийн тамир спортын наадмыг 04 дүгээр сарын 26-аас 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд сагсан бөмбөг, гар

бөмбөг, ширээний теннис, дартс гэсэн спортын 4 төрлөөр амжилттай зохион байгууллаа.



Зураг 21. Байгууллагын биеийн тамир, спортын наадмын үеэр

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагуудын дунд зохион байгуулсан анхдугаар “Спорт наадам” сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс гэсэн багийн 3 төрөлтөөр 2018 оны 11 дүгээр сарын 3,4-ний өдрүүдэд НЗДТГ-ын спорт зааланд болж амжилттай өндөрлөлөө. Уг тэмцээнд Нийтлэг Үйлчилгээний газрын баг тамирчид өндөр амжилт гарган ажлын байрны дасгал, дартсын төрөлд аваргын алтан медаль, гар бөмбөгийн төрөлд эрэгтэй баг мөнгөн медаль, эмэгтэй баг хүрэл медаль, сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй, эмэгтэй баг тус бүр 4-р байрт орж багийн нийлбэр дүнгээрээ тэргүүн байранд шалгарч “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ”-н эздээр тодорсон амжилтыг үзүүлэв.



Зураг 22. Гар бөмбөгийн тэмцээний медалийн эзэд



Зураг 23. Дарсын аваргууд



Зураг 24. Аваргын цомоо авлаа

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Нутгийн захиргааны байгууллагуудын спортын анхдугаар наадамд ажлын байрны дасгал, дартс гэсэн 2 төрлөөр хэрэгжүүлэгч агентлагуудаас шалгаран амжилттай оролцлоо.



Зураг 25. “Улаанбаатар Марафон”-ы үеэр



Зураг 26. Ажлын байрны дасгал хөдөлгөө тэмцээний үеэр



Зураг 27. НҮГ-ын баг тамирчид

### 3.1.8 Өндөр настан, ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн талаар:

Жил бүрийн сар шинийн баяр болон ахмадын өдрөөр НҮГ-ээс гавъяаны амралтанд гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэн хүлээн авдаг уламжлалтай. 2018 оны сар шинийн баяр, ахмадын өдрөөр газрын дарга асан Т.Дашням болон 83 ахмадуудад хүндэтгэл үзүүлэн хүлээн авч, газрын дарга гарын бэлэг гардууллаа.

### 3.1.9 Санхүү, аж ахуйн чиглэлээр:

2018 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, хугацаанд нь НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн татварын газарт хүргүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, шилэн данс вэб сайтад 3 төрлийн тайланг хугацаанд нь сар бүр байршуулан ажилласан.

НҮГ-ын 2018 оны А/55 тушаалаар Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийг шинэчлэн байгуулж, хагас жилийн тооллогын комиссыг А/42 дугаар тушаалаар байгуулж, зөвлөлийн дарга С.Доржсүрэнгээр ахлуулсан комиссын бүрэлдэхүүн хуваарийн дагуу ажиллаж, актлах хөрөнгө болон, бүртгэлтэй бүртгэлгүй хөрөнгийн судалгааг гаргаж, 87 төрлийн 14659815 төгрөгийн аж ахуйн эд материалуудыг газрын даргын А/57 дугаар тушаалаар акталсан. НҮГ-ын даргын 2018 оны А/64 дүгээр тушаалаар жилийн эцсийн тооллогыг Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга С.Доржсүрэн даргатай ажлын хэсэг батлагдсан хуваарийн дагуу гүйцэтгэж байна.

<b>Орлогын дүн /мян.төг/</b>	<b>4481924.8</b>
1. Үндсэн үйл ажиллагааны орлого	71500.0
2. Туслан үйл ажиллагааны орлого	723449.1
3. Төсвөөс урсгал санхүүжилт	3686975.1
<b>Бараа үйлчилгээний зарлагын дүн /мян.төг/</b>	<b>4208790.9</b>
- Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	1926522.1



- АОНДТ шимтгэл	222903.5
- Бараа ашиглалтын зардал:	621990.7
- Хангамж бараа материалын зардал	44516.8
- Норматив зардал	4107.5
- Эд хогшил, урсгал зардал	422386.3
- Төлбөр хураамж	679577.2
- БҮБЗардал	27499.0
- Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	36384.2

### 3.1.10 Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Тогтоол шийдвэр, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж дотоод хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам", 2014 оны А/279 дүгээр захирамжаар баталсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ыг тус тус удирдлага болгон ажилласан.

Тайлант хугацаанд дээд газраас ирсэн тогтоол шийдвэр, захирамжаас Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын чиг үүрэгт хамаарах заалтыг хяналтанд авч, хэрэгжилтийн явц, үр дүнг тооцон ажилласан. Үүнд:

Улсын Их Хурлын 1 тогтоолын 1 заалт, Засгийн газрын 3 тогтоолын 17 заалт, Засгийн газрын 1 хуралдааны тэмдэглэлийн 1 заалт, Засгийн газрын 2 албан даалгаврын 13 заалт, НИТХ-ын Тэргүүлэгчидийн 2 тогтоолын 5 заалтуудын биелэлт 100%-ийн биелэлттэй байна.

Нийслэлийн Засаг даргын 10 захирамжийн 13 заалт, НЗД-ын зөвлөлийн хурлын 2 тэмдэглэлийн 2 заалт, НЗД-ын 1 албан даалгаврын 8 заалтуудыг өөрийн чиг үүрэгт хамааруулан биелэлтийг 100% гүйцэтгэсэн.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-р бүлгийн 1 заалт, 3-р бүлгийн 1 заалт, 4-р бүлгийн 2 заалт, 5-р бүлгийн 3 заалт, нийт 4 бүлгийн 7 заалтын хэрэгжилтийг хяналтанд авч, шинжилгээ үнэлгээ хийж ажиллаа. Эрх зүйн актын хэрэгжилтийн дундаж үзүүлэлт нь 100 хувийн гүйцэтгэлтэй, 100 гэсэн үнэлгээтэй байна. Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн тоо өмнөх оныхоос 6%-иар өссөн бөгөөд үүний дагуу манай байгууллагатай нийцүүлэн хэрэгжүүлэх заалт 2018 онд 5% өссөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж 2018 оны үр дүнгийн гэрээгээр гүйцэтгэхээр төлөвлөгдсөн 32 арга хэмжээ, 2 тусгай захиалгат бүтээгдэхүүнийг хяналтанд авч гүйцэтгэлийн явцад хяналт тавин ажилласан.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 3.1.6 дахь заалт /хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ хэрэглэгч, оролцогч болон олон нийтийн оролцоог хангасан байх/-ын хэрэгжилтийг хангах зорилгоор, зоогийн газруудад санал хүсэлтийн дэвтэр ажиллуулж үйлчлүүлэгчдийн санал хүсэлтийг тогтмол авч ажиллахын зэрэгцээ хэрэглэгчийн үнэлгээг тогтоох зорилгоор оны эхэнд буюу 2018 оны 01 дүгээр сард 1556 төрийн албан хаагчаас санал асуулга авч нэгтгэхэд НҮГ-ын үйл ажиллагаанд 49.1% нь сайн, 31.6% нь дунд, 19.3% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байна.

2018 оны 11 дүгээр сард зохион байгуулсан “Таныг сонсьё” аяны хүрээнд НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбаруудын 1200 орчим төрийн албан хаагчдаас дахин санал хүсэлтийг авахад санал асуулгад оролцогчдын 79,3% нь сайн, 17,1% дунд, 3,6% нь хангалтгүй үнэлгээ өгснийг оны эхэнд авсан санал асуулгын дүнтэй харьцуулахад үнэлгээ харьцангуй өссөн байна. Энэ нь өмнөх санал асуулгын дүнгийн мөрөөр авсан арга хэмжээний үр дүн гэж үзэх байна.




График 4. Хэрэглэгчдээс 1, 4 дүгээр улиралд авсан санал асуулгын дүн



Зураг 28. “Таныг сонсьё” аяны үеэр

Мөн өөрийн байгууллагын үйл ажиллагааг дүгнэх зорилгоор ажилтан, албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг 10 дугаар сард хаалттай 10, нээлттэй 1 асуултын хүрээнд авлаа. Тус судалгаанд 218 буюу нийт ажилтан, албан хаагчдын 83,5% нь хамрагдаж, байгууллагаас зохион байгуулж байгаа үйл ажиллагаа, мэдээ мэдээллийн хүртээмж, удирдлагын харилцааны ёс суртахуун, ажилтан, албан хаагчдад тулгарч буй асуудлыг түргэн шуурхай шийддэг байдал, хамтран ажиллагсад болон ажлын орчин, нөхцлийн талаарх санал асуулгад 82,6% сайн, 14,2% нь дунд, 3,2% нь хангалтгүй үнэлгээ өгсөн байгаа нь ажилтан, албан хаагчид захиргаанаас

зохион байгуулж байгаа, ажил, удирдлагын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгааг харууллаа.

2018 оны дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөөний дагуу байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг баталсан удирдамжийн дагуу:

- 03-р сард баталсан “Зоогийн газрын эрүүл ахуй, хоол үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллыг шалгаж, зөрчил дутагдал, эрсдлээс урьдчилан сэргийлэх дирдамж”,
- 03-р сард баталсан “Инженерийн байгууламжийн ашиглалт, шугам сүлжээний хэвийн ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”,
- 04-р сард баталсан “Цэвэрлэгээ үйлчилгээний стандартад дотоод хяналт шинжилгээг зохион байгуулах удирдамж”,
- 05-р сард баталсан “Зоогийн газар, цайны газруудад дотоод хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”,
- 08-р сард баталсан “Дээд газрын тогтоол шийдвэр, захирамж, албан даалгаврын тус газрын чиг үүрэгт хамааралтай заалтуудын биелэлтэд хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж”,
- 08-р сард баталсан “НҮГ-ын зоогийн газар, цайны газруудад эрүүл ахуй, хоол үйлдвэрлэл, түүний хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж”
- 10-р сард баталсан “НЗЗ-ны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээний стандартын хэрэгжилт, аюулгүй ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж”,
- 10-р сард баталсан “Байр ашиглалтын албаны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж”,
- 11-р сард баталсан “Зоогийн газрын эрүүл ахуй, хоол үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалалд хяналт-шинжилгээ хийх ажлын хэсгийн удирдамж”-ийн

дагуу тус тус ажлын хэсэг томилогдон хяналт-шинжилгээг 9 удаа зохион явуулсан ба өмнөх онд 7 удаагийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж байсан нь хяналт шалгалтын давтамжийг нэмэгдүүлж, аливаа эрсдэл, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлж, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2018 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 03 дугаар албан даалгаврын хүрээнд НҮГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн шийдвэрээр ажилтан, албан хаагчдын цаг ашиглалтад авах арга хэмжээ, түүний хариуцлагын тогтолцоог ур чадварын нэмэгдэлтэй нь уялдуулан тооцож байхаар шийдвэрлэж ур чадвар дүгнэх журманд нэмэлт өөрчлөлт оруулсан. Цагийн бүртгэлийг сар бүр гарган, цагийн хоцрогдолтой ажилтан, албан хаагчдад 3 төрлийн сануулах хуудсыг тарааж ур чадварын нэмэгдлээс шат дараатайгаар тооцон ажилласан ба 289 ажилтан, албан хаагчаас 09 дүгээр сард 90, 10-р сард 58 сануулах хуудас тарааж байсан бол 11-р сарын байдлаар 32 сануулах хуудас тараасан ба ажлын цагийн хоцрогдол, эрт явалт 45%-иар буурсан байна.



График 5. Цаг ашиглалтын байдлыг 9, 10, 11 сараар харуулбал

### 3.1.10 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ийн талаар:

Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлэх үзүүлэлтүүдийг дүрмээр хүлээсэн үндсэн 3 чиг үүргийн хүрээнд нийцүүлэн тодорхойлж, шалгуур үзүүлэлтийг тооцоолох томъёолол, загварчлалыг гаргаж 2017, 2018 оны үйл ажиллагааны үнэлгээг үнэлсэн. Бидний гаргасан томъёоллоос үнэлгээг харьцуулж харахад 2018 онд үнэлгээ өссөн харагдаж байгаа хэдий ч шалгуур үзүүлэлтийг тооцоолох томъёо, аргачлалыг дахин нягтлах, мэргэжлийн байгууллагаас арга зүйн зөвлөгөө авч ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

### 3.2 НЗЗ-ны байруудын инженерийн байгууламжийн ашиглалт, ус, дулаан, цахилгааны хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр:

НҮГ-ын Байр ашиглалтын алба нь албаны дарга 1, инженер 3, нийт 42 хүний бүрэлдэхүүнтэйгээр НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбарыг ус, дулаан, цахилгаан, холбоо, засвар тохижилтонд онцгой анхаарч, инженерийн байгууламжийн байнгын найдвартай, жигд үйлчилгээгээр ханган ажиллаж байна.

Алба нь НЗЗ-ны 5-н байранд байрлан төрийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудтай “Байр Ашиглалтын” гэрээ байгуулан гэрээний дагуу цахилгаан, дулаан, инженерийн шугам сүлжээ, цахилгаан шат зэргийг барилгын норм дүрэм, стандартын дагуу шуурхай үйлчилгээ үзүүлж ажил үүргээ 24 цагаар тасралтгүй явуулж байна. Мөн Нийтлэг үйлчилгээний газрын гамшгаас хамгаалах төлөвлөгөө, НЗЗ-ны байруудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллалаа.

2018 онд НЗЗ-ны байруудын инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг байр ашиглалтын албаны инженерүүд 7 хоног тутам, албаны дарга сард 1 удаа тус тус тогтмол хийж, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж, техникийн болзошгүй саатлаас урьдчилан сэргийлж ажиллаж байна.

#### 3.2.1 Цахилгаан хангамжийн чиглэлээр:

- НЗЗ-ны 5-р байрны А корпус хойд талын жигүүрийн цахилгааны хаалттай хуваарилах байгууламжийн гадна талын ерөнхий кабелийн шугамд гэмтэл гарсаныг дуудлага өгч УБЦТС-ний Ашиглалтын хэлтсээс гэмтлийг

тодорхойлуулж, газар шорооны ажил, холболтын муфьт хийж аюулгүй ажиллагааг хангав.



*Зураг 29. Цахилгааны ерөнхий кабелийн шугамд гарсан гэмтлийг засварлаж буй байдал*

- НЗЗ-ны 5 дугаар байрны байрны А корпус, Б корпусын хооронд цахилгааны кабель, щит угсарч, цахилгааны ачааллыг бууруулж фазыг тэнцвэржүүлж засвар үйлчилгээг хийлгэсэн.



*Зураг 30. 5 дугаар байранд шинээр тависан цахилгааны шитыг монтажилсан байдал*

- НЗЗ-ны 2 дугаар байрны 2, 4, 5, 6, 9-р давхрын цахилгааны щитны хуваарилах самбарын 32 ампертай нийт 35ш автомат таслуурыг шинээр сольж хэвийн ажиллагаатай болгов.
- Хангарди ордны нөөц тэжээл болох дизель генераторыг автомат горимд шилжүүлэн АВР сэлгэн залгагчийг бүрэн засварлаж, туршилтын тохируулгыг хийж ажиллаж байна.
- Зүүн Цахилгаан түгээх салбартай хамтран ажиллах гэрээний дагуу хувиарлах байгууламжийн тоолуур, гүйдлийн трансформаторыг хэмжилзүйн газраар баталгаажуулсан.
- Цахилгаан эрчим хүчийг хэмнэх зорилгоор тайлант хугацаанд техникийн комиссын 68 акт үйлдэж, лед гэрэл 600ш, лед гэрлийн ламп 1600 ш, дросель 50 ш, 1 фазын ба 3 фазын автомат 45ш, шатны мэдрэгчтэй гэрэл 12ш-ыг тус тус сольж, НЗЗ-ны байруудын гадна фасадны гэрэлтүүлэг, рекламн гэрэлтүүлгийг цагийн релегээр удирдах ажиллагааг жигдрүүлснээр 2017 оны мөн үеийн

цахилгаан эрчим хүчний зардлаас 16,178,639 төгрөгийн хэмнэлт гарган ажилласан байна.



Зураг 31. Н33-ны байруудын ламп, гэрлүүдийг сольж буй байдал

- “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Зүүн түгээх төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу тоолуур, гүйдлийн трансформатор баталгаажуулах, хуваарилах байгууламжийг шинэчлэн тоноглов.

### 3.2.2 Сантехник, инженерийн шугам сүлжээний чиглэлээр:

- Тайлант хугацаанд Н33-ны байруудын дээвэр дээрх ариутгах татуургын үнэр гаргагч битүүрч тагларсаныг засварлан хэвийн ажиллагаад оруулсан бөгөөд сантехникийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг ханган, өдөр дутмын инженерийн шугам хоолойн эвдрэл гэмтэл, ус алдалт, төвийн нэгдсэн дулааны шугам хоолойтой холбоотой ажлуудыг 24 цагаар шуурхай хийж гүйцэтгэсэн.
- Н33-ны 1, 2, 3, 4 байруудын ариун цэврийн өрөөнд сэнс тавих, сэнс цэвэрлэх, агааржуулалтын хэвтээ болон босоо шугамыг шинээр сольж хийлээ.
- Н33-ны байруудын сантехникийн шугам хоолойн тоноглол болох сантехникийн материал, угаалтуурын сифон хоолой 154 ш, уян хоолойн писсуарийн сифон 76 ш, халаагуур 5 ш, почкины ком 57 ш, писсаур мэдрэгч 24ш, батарей 240 ш, суултуур 4 ш, холигч 35 ш, гармошик 72 ш, шугамын холболт 147 метр, ариун цэврийн өрөөний сэнс 25 ширхэгийг тус тус техникийн комиссийн акт үйлдэн сольж, зарим сантехникийн тоноглолыг засварлаж, хэвийн ажиллагааг ханган ажилласан.
- Хангарди ордны 1 давхрын хэвлэл мэдээлэлийн өрөөний цуваагаар холбогдсон нийт 4ш халаах хэрэгслийн төгсгөлийн хэсэгт даралт хүрдэггүйн улмаас халдаггүй байсныг коллектрийн системд шилжүүлэн холбож хэвийн ажиллагаанд оруулсан нь өрөөний температур нэмэгдэж ажилчид ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлсэн болно.
- Н33-ны 4 дүгээр байрны халаалтын гадна шугамын ашиглалтын хугацаа хэтэрч ус алдаж байсан нийт 65м 3 хос шугамыг шинэчлэн сольж хэвийн ажиллагаанд оруулсан.
- Н33-ны 5 дугаар байрны хэрэгцээний халуун усны хуучирсан хурдны ус халаагуурыг ялтсан бойлур болгон дулаан солилцуурыг нэмэгдүүлсэн.
- Н33-ны 3 дугаар байрны халаалтын ерөнхий магистрал шугам ашиглалтын хугацаа дуусан элэгдэж муудсаныг сольсон

зэрэг ажил үйлчилгээг үзүүлж, өрөөний халаалт, сантехникийн хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

Тайлант хугацаанд НЗЗ-ны 5 байр, 3 төвийн салбараас нийт 2398 дуудлага ирсэнээс мужааны 948, цахилгааны 775, сантехникийн 580, холбоо дохиоллын 95 дуудлагыг цаг алдалгүй шуурхай засварлаж ажиллалаа.




График 6. Дуудлагын төрөл

### 3.2.3 Бусад ажлын хүрээнд:

- Хангарди ордны лифтийг “Сигма Тек” ХХК-тай хамтран хөргөх төхөөрөмжийн сэнсийг засварлаж, 24 удаагийн засвар үйлчилгээг гүйцэтгэсэн бөгөөд НЗЗ-ны 4-р байрны 3 лифтийг “Хандок Инженеринг” ХХК, “Шримекс” ХХК-тай тус тус хамтран 60 удаагийн үзлэг, засварыг хийж хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.



Зураг 32. “Сигма Тек” ХХК-ын ажилтнууд үзлэг хийж байгаа байдал

- НЗЗ-ны 4 дүгээр байрны 12 дугаар давхарт агааржуулалтын сэнсний моторыг цахилгааны шитэд холбож хэвийн ажиллагааг хангалаа. Тус байрны 1-12 дугаар давхруудын нийтийн эзэмшлийн коридор, ариун цэврийн өрөө, ажлын өрөөний

цонхоны 38 ширхэг эвдэрсэн бариулыг сольж, мөн сантехникийн хаалтуудад сальник шахаж засвар үйлчилгээг хийсэн.

- ОБЕГ-тай хамтран НҮНТ-ийн салбаруудад галын аюулгүй байдлын үзлэг хийж зөрчил дутагдлыг арилгуулав. Тус салбаруудын ариун цэврийн өрөөний агааржуулалтын сэнс, шалны хүрээ, хаалганы цоож, лед гэрэл, цахилгааны монтажны утсыг тус тус сольж хэвийн ажиллагааг хангаж ажиллаа.
- НЗЗ-ны 1, 2, 5-р байруудын хурлын танхимуудад тайлант хугацаанд нийт 1956 хурал, зөвлөгөөн, арга хэмжээ, хүндэтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулагдсанаас НЗЗ-ны 1 дүгээр байрны “А” танхимд 538 удаа, “Б” танхимд 219 удаа, Вип танхимд 133 удаа, 2 дугаар байранд 700 удаа, 5 дугаар байрны хурлын танхимд 292 удаа тус тус явагдсан ба хурлын заалны техник, тоног төхөөрөмж, бэлэн байдлыг хангаж ажилласан.
- Тайлант хугацаанд сайтад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 30 мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж, 20 удаагийн ажлын байрны сул орон тоог тухай бүр нь нийтэд зарлаж ажилласан. Мөн байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг ил тод байдлын үндсэн 4 чиглэлээр [www.khangardi.mn](http://www.khangardi.mn) сайтад нээлттэйгээр байршуулан ажиллаж байна.
- НЗЗ-ны 5А дугаар байрны дээврийн 1055 м<sup>2</sup> талбайд хэсэгчилсэн засварын ажлыг “Мөнгөн оройт цамхаг” ХХК-тай гэрээ байгуулж гүйцэтгүүлэн томилогдсон ажлын хэсэг хугацаанд нь хүлээн авсан.



Зураг 33. НЗЗ-ны 5 дугаар байрны дээврийн засварын өмнөх ба дараах байдал

- НЗЗ-ны байруудын аюулгүй байдал, хэвийн ажиллагааг сайжруулах үүднээс НЗЗ-ны 2, 3, 4, 5 дугаар байруудад хөдөлгөөнт аналого камер 1, дотор аналого камер 1, дотор IP камер 21, гадна IP камер 8, IP HD камер 1, галын дохиолол, түүний дагалдах тоног төхөөрөмжүүдийг тус тус суурилуулж, байруудын камерын хяналтыг хэвийн явуулж, аюулгүй байдлыг ханган ажилласан.
- НЗЗ-ны 2-р байрны 6130м<sup>2</sup>, 4 дүгээр байрны 6410м<sup>2</sup> талбай бүхий гадна шилэн фасад угаах ажлыг “Хүн аалз” ХХК-иар гүйцэтгүүлсэн.





*Зураг 34. НЗЗ-ны 2, 4 дүгээр байрны шилэн фасад угааж байгаа байдал*

- Хангарди ордны ариун цэврийн өрөөнүүдийн нэгдсэн ерөнхий агааржуулалтын системын шугам хоолойг барилгын дээвэр дээр өндөрлөн агаарын урсгалыг сайжруулах болон ариун цэврийн өрөөний сэнснүүдийг бүрэн шинэчилж, шугам хоолойн битүүмжийг сайжруулах угсралтын ажлыг “Дельта эйр кондишн” ХХК-иар гүйцэтгүүлсэн.



*Зураг 35. Хангарди ордны ариун цэврийн өрөөний агааржуулалтын системийн засварын ажлын үеэр*

- Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/142 дугаар захирамжаар төсөл, арга хэмжээний худалдан авах эрхийг НҮГ-т шилжүүлсэн. Нийслэлийн Зураг төслийн хүрээлэнгээр уг ажлын зураг, төсөв хийгдэж батлагдсанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2 дугаар зүйл, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2 дугаар заалтуудын дагуу Мөнгөн оройт цамхаг ХХК-г НЗЗ-ны 4 дүгээр байрны шат, Сагсай өргөө ХХК-г НЗЗ-ны 2 дугаар байрны хэрэглээний халуун усны шугамыг шинээр татах ажлын гүйцэтгэгчээр тус тус сонгон шалгаруулсан. Эдгээр ажлын явцыг Нийслэлийн Хөрөнөгө оруулалтын газар болон Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын хяналтын инженерүүдтэй хамтран ажлын үе шат, гүйцэтгэл бүрт хяналт тавьж, Нийслэлийн Хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газраас томилогдсон ажлын хэсэг 2018 оны 12 дүгээр сарын 14, 15-ны өдрийн комиссын актаар тус тус хүлээж авсан.



*Зураг 36. НЗЗ-ны 4 дүгээр байрны дугуй шатны засварын ажлын дараах байдал*



*Зураг 37. Хангарди ордны хэрэглээний халуун усны шугам шинээр тавих ажлын үеэр*

### 3.3 Цэвэрлэгээ, үйлчилгээ, эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээний чиглэлээр:

Нийтлэг үйлчилгээний газрын Үйлчилгээний алба нь цэвэрлэгээ үйлчилгээ ба зоогийн үйлчилгээний гэсэн үндсэн 2 чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбарт ажиллаж буй төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай нөхцлийг хангасан цэвэрлэгээ үйлчилгээ, Хангарди ордны зоогийн газар, НЗДТГ, Улаанбаатар чуулгын цайны газруудад хоол, зоогийн үйлчилгээг тус тус чанар стандартад нийцүүлэн мэргэжлийн төвшинд үзүүлэн ажиллаж байна.

#### 3.3.1 Нийслэлийн засаг захиргааны байруудын цэвэрлэгээ үйлчилгээ

Нийслэлийн засаг захиргааны байруудын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, тогтмолжуулах үүднээс байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна. Нийт байруудад хийгдэх цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгалын хуваарийг шинэчлэн гаргаж, албаны хэмжээнд баталгаажуулан ажиллалаа.

Тайлант хугацаанд бүх байруудад их цэвэрлэгээг 262 удаа зохион байгуулсан.

Орчны тохижилтонд ариутгал, халдваргүйжүүлэлтийг өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан байр тус бүр сард 2 удаа нийт 24 удаа зохион байгуулж, 4-н байрны 15000м<sup>2</sup> талбайд мэргэжлийн эрх бүхий компаниар ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэсэн.

НЗЗ-ны байруудын дээврийн цэвэрлэгээ, ус зайлуулах хоолойн ариутгал цэвэрлэгээг 4 байранд нийт 48 удаа хийсэн байна.

Цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг сайжруулах шинэлэг санаа, санаачилгыг хэрэгжүүлж цэвэрлэгээний чанарыг сайжруулах зорилгоор үйлчлэгч тус бүрт өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний бүртгэл, хяналтын хуудас гаргаж, ариун цэврийн өрөөний цэвэрлэгээний давтамжийг тогтмолжуулж, нийслэлийн агентлагуудын дарга нарын өрөөний үйлчлэгчийн ажлыг үнэлүүлэх хуудас гаргаж, хяналтын карт хөтөлж хэвших зэрэг ажлыг шинээр нэвтрүүлсэн. Мөн байр бүрт санал хүсэлтийн дэвтэр ажиллуулж түүнд тусгагдсан хүсэлт, санал, гомдол, шүүмжлэлийг цаг алдалгүй шийдвэрлэж ажиллалаа.



*График 6. НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын санал хүсэлтийг дэвтэрийн мэдээ*

НЗЗ-ны байруудад цэвэрлэгээний шуурхай ажлын баг томилон ажиллуулж байна. Тус шуурхай ажлын баг цэвэрлэгээг байр тус бүрт 1-2 удаа хийж, өдөр тутмын ажлын бэлтгэл хангаж, багаж, материалын захиалгыг өгч, бүртгэлжүүлж ажилласан.

НҮНТ-ийн Драгон салбарын үйлчилгээний хамт олны санаачлагаар ариун цэврийн өрөө, оффисын өрөөнд цэвэрлэгээ хийхдээ ашиглах “ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙЖ БАЙНА” гэсэн пайзыг шинээр нэвтрүүлээ.

НЗЗ-ны 5 дугаар байр “А” корпусын хамт олны санаачилгаар “Цэвэрлэгээний бодис орлуулах арга” танилцуулах өдөрлөг зохион байгууллаа. Энэхүү өдөрлөгт 5 байр 4 салбарын багийн ахлагч нар, менежерүүд, захиргааны холбогдох албан хаагчид зэрэг 70 орчим хүн оролцож туршлага солилцон, эрүүл өдрийн зоогийн талаар мэдээлэл авч, хямд төсөр аргаар ажлын орчин хэрхэн таатай байлгах чиглэлээр мэдээлэл авсан.

Албаны хэмжээнд “Өөрчлөлтийг өөрөөсөө эхлүүлбэ, шинэчлэлийг бүгдээрээ хэрэгжүүлбэ” уриатай аяныг 1 сарын хугацаанд зохион байгууллаа. Энэхүү аяны хүрээнд 5 байр “Инээмсэглэлийн 3 өдөр” арга хэмжээг зохион байгуулсан ба төрийн албан хаагчдыг өглөө бүр угтан авч орой бүр үдэж өгөх үйлчилгээ үзүүлэв.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран хэрэгжүүлсэн “Тамихны ишгүй байгууллага- Тамихгүй орчин” аянд нэгдэж НЗЗ-ны байруудад томилогдсон шуурхай ажлын багийн ажилчид эргүүл хийж ажлын байранд тамхи татаж буй ажилтан албан хаагчидад анхааруулга сануулга өгч, ажиллахын зэрэгцээ “Тамхины эсрэг” өдөрт зориулан тамхи татдаг албан хаагчдад модон чихэр, тамхины хор нөлөөлийн талаар ухуулах үг тарааж, тамхи татахгүй байхыг уриалсан арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд 50 гаруй байгууллагын 200 гаруй албан хаагч хамрагдлаа.

Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж байгаа цэвэрлэгээ үйлчилгээний стандартын хэрэглээг ямар түвшинд байгааг илрүүлэх зорилгоор 3 байрны 50 үйлчилгээний ажилтнаас цэвэрлэгээ үйлчилгээний стандартын анхан шатны мэдлэгийг шалгах тестийн шалгалтыг авч үзэхэд стандартын анхан шатны мэдлэг мэдээлэл бүрэн дүүрэн байгаа бөгөөд шалгалтанд хамрагдсан үйлчилгээний ажилчдын 80% нь хангалттай үнэлгээ авсан.



*Зураг 38. Цэвэрлэгээ үйлчилгээний стандартын анхан шатны мэдлэг шалгах тестийн явц*

Нийслэлийн засаг захиргааны байруудын тохижилтын чиглэлээр 2018 оныг “Иргэдийн оролцоотой-амьдрах орчныг сайжруулах жил” болгон зарласантай

---

холбогдуулан Нийтлэг үйлчилгээний газар нь “Төрийн албан хаагчдын ажиллах орчныг сайжруулах жил” болгон зарлаж, энэ хүрээнд үйлчилгээний ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх, шинэ санал санаачилгыг дэмжих, идэвхижүүлэн урамшуулах зорилгоор “Эрүүл тохилог ажлын байр” сэдэвт 1 сарын хугацаатай болзолт уралдааныг зарлан явуулсан.

Уг болзолт уралдаан төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан, эрүүл тохилог ажлын байрыг бүрдүүлэх чиглэлээр шинэ бүтээл, оновчтой санал гаргаж тухайн байр, орчин нөхцөлдөө амжилттай хэрэгжүүлж нэвтрүүлсэн, санаачилж хийсэн ажил нь өнгө үзэмжтэй, зохистой зөв шийдэлтэй, сэргээн засварлаж сайжруулсан, тохижуулсан, хамт олны оролцоог хамруулж өөрсдийн боломж бололцоог ашигласан, багаар ажиллаж эвсэг хамтач үйл ажиллагааг харуулсан шинэлэг ажил болсон.

НЗЗ-ны 1, 2 дугаар байруудын гадна тохижилтыг сайжруулж, өнгө үзэмжтэй, зөв шийдэлтэй тохижилтын ажлуудыг өөрсдийн нөөц бололцоо, хандив тусламжаар хийж гүйцэтгэсэн.



*Зураг 39. НЗЗ-ны 1, 2 дугаар байрны гадна талбайг тохижуулах ажлын явц*

Тасалгааны цэцэгний төрөл, агаар цэвэршүүлэх увидас бүхий цэцгийн арчилгаа, ангилал нэртэй төрөлжүүлсэн 3 боть гарын авлагыг НЗЗ-ны 2 дугаар байрны үйлчилгээний хэсгийн хамт олонд танилцуулж, түүний дагуу байруудад 1 хүн 2 цэцэг шинээр нэмж тарих арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүллээ. Үүний үр дүнд байр бүрт 20-100 ширхэг цэцэг шинээр нэмэгдэж төрийн албан хаагчдад эрүүл цэвэр орчин бүрдүүлж ажилласан. Тасалгааны цэцэг, цэцэгжүүлэх зорилтод ажлын хүрээнд 252 ширхэг цэцэг шинээр нэмэгдүүлж, зохих газарт нь байршуулан ажилласан. Мөн энэхүү ажлын хүрээнд цэцгийн ваар ижилсүүлэх, гадна талбайд цэцгийн мандлын үрсэлгээ суулгах, гадна талбайг зүлэгжүүлэх, суулгац суулгах, хаягдал алчуураар цэцгийн сав хийх зэрэг ажлууд хийгдсэн. НЗЗ-ны байруудад нийт 10 цэцгийн мандал шинээр байгуулж, ойролцоогоор 500 м<sup>2</sup> орчим талбайд зүлэгжүүлэх ажил хийгдсэн байна.



*Зураг 40. Тасалгааны цэцэг, цэцэгжүүлэх ажлын үеэр*

НЗЗ-ны 1, 3, 5а дугаар байрууд, НҮНТ-ийн Дүнжингарав, Драгон салбаруудыг дугуйн зогсоолтой болгох ажлыг үйлчилгээний ажилчид өөрсдийн хүчээр хийж гүйцэтгэсэн.



*Зураг 41. Дугуйн зогсоол*

Байруудын гадна орчны тохижилтыг сайжруулах зорилгоор Нийслэлийн захирагчийн ажлын албанд хүсэлт гаргаж, гадна талбайн хогийн сав 10 ширхэг, сандал 14 ширхэгийг шийдвэрлүүлж, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудад байрлуулсан.



*Зураг 42. Шинээр байрлуулсан сандал, хогийн сав*

НҮНТөвийн Дүнжингарав, Мишээл салбарын үйлчилгээний ажилчид төрийн албан хаагчдын ажиллах орчин, нөхцлийг сайжруулах зорилгоор өдрийн цайны цагаар нарлах зориулалт бүхий саравч болон ногоон байгууламж бүхий амралтын цэгийг байгуулсан.



*Зураг 43. Шинээр хийсэн саравч, ногоон байгууламж*

НЗЗ-ны 5А дугаар байрны "А" корпусын үйлчилгээний ажилтнууд мөөгөнцөрдсөн шатны хонгилыг засварлах ажлыг гүйцэтгэсэн.



Зураг 44. НЗЗ-ны 5-р байрны А корпусын шатны засвар

НЗЗ-ны 1, 4 дүгээр байрны үйлчилгээний ажилчид тухайн байранд үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын дэмжлэгтэйгээр төрийн албан хаагчдын амралтын цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх зорилгоор чийрэгжүүлэлтийн өрөөг өөрсдийн хүчээр шинээр тохижуулсан.



Зураг 45. НЗЗ-ны 4 дүгээр байрны чийрэгжүүлэх өрөө

Үйлчилгээний ажилчдын өрөөг тохижуулах, шинэчлэн засварлах ажлууд нийт 8 байр 4 төвийн хэмжээнд гүйцэтгэл 100% хийгдэж эрүүл, тохилог ажлын байранд ажиллах нөхцөл бололцоо хангагдсан.



Зураг 46. Үйлчилгээний ажилчдын өрөөг тохижуулахын өмнөх болон дараах байдал

НЗЗ-ны байруудын нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээг өөрсдийн нөөц бололцоог ашиглан баг хамт олноороо хийж гүйцэтгэсэн ба нийт 1800 гаруй м<sup>2</sup> талбайд, 4 дүгээр байрны В1 болон 1 дүгээр давхарын нийтийн эзэмшлийн талбайн засвар үйлчилгээг тус тус баг хамт олноороо хийж гүйцэтгэв.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орох, гарах гарцыг НЗЗ-ны 5А, 5В байрууд, НҮНТ-ийн Мишээл салбаруудад ажилчид өөрсдийн хүчээр хийсэн.



*Зураг 47. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарц*

### 3.3.2 Эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээ

Тайлант хугацаанд хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг өндөр хэмжээнд зохион байгуулах, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд анхааран ажиллалаа.

Хүнсний бараа материалын эрүүл, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд үндэсний хэмжээний 6 байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу татан авалтыг зохион байгуулж, бараа материалын гарал үүслийн бичиг, шинжилгээний бичиг, хүлээн авах үеийн дүгнэлт зэргийг тухай бүр нь бүртгэлжүүлэн ажиллаж байна.

Хагас жил тутам заавал хамрагдах эрүүл мэндийн үзлэгт зоогийн газар, цайны газруудын ажилтнуудыг ХУД-н эрүүл мэндийн төв, ЧД-ийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран 100% эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан бөгөөд ЧД-ийн МХХ болон СБД-ийн МХХ-т хүсэлт гарган НЗЗ-ны 1, 2, 5 дугаар байрнуудын, зоогийн газруудын ундны усны шинжилгээг өгсөн. Шинжилгээгээр ундны усны хэрэглээг бүрэн хангасан дүгнэлт гарсан. Мөн “Цэвэр-Орчин” ХХК-тай хамтран гурван зоогийн газрын товлот ариутгал, халдваргүйтгэлийг 4 удаа хийлгэж үр дүнг 100% тооцон ажиллаж байна.

Зоогийн газар болон цайны газрын өдрийн хоолны цэсийг баяжуулж, технологи картыг нэг бүрчлэн шинэчлэн боловсруулсан бөгөөд хоолны амт чанарыг сайжруулах үүднээс нийт 186 нэр төрлийн хоол, зуушаар меню гаргаж, 14 хоногийн давтамжтай үйлчилж байгаа бөгөөд 12 дугаар сарын 05-ны байдлаар давхардсан тоогоор 24630 хүнд зоогийн үйлчилгээ үзүүлсэн.





*График 7. 2017, 2018 оны хоолны нэр төрөл, үйлчлүүлэгчийн тооны өөрчлөлт*

Нийслэлийн Хангарди ордны Зоогийн газар 12 дугаар сарын 05-ны байдлаар 81 удаагийн хүндэтгэлийн хүлээн авалт зохион байгуулж 4035 хүнд үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ 9 удаагийн катеринг үйлчилгээгээр 460 хүнд, 29 удаагийн хурлын цай завсарлагааг тус тус зохион байгуулж 3239 хүнд үйлчилсэн.



*График 8. Хээрийн болон дээд хэмжээний хүлээн авалтын үйлчилгээний тооны өөрчлөлт*

Хангарди ордны зоогийн газар болон Тамгын газрын цайны газрын санал хүсэлтийн дэвтэрт нийт 32 санал хүсэлт бүртгэгдсэнээс 25 сэтгэгдэл нь бидний ажлыг дэмжсэн, 3 шүүмжлэл нь аяга тавгийн угаалга цэвэрлэгээ, хоолны амт чанартай холбоотой байсан бол 4 санал нь ахлах тогооч, тогооч нарыг сайшаасан байлаа.

Хээрийн болон катеринг үйлчилгээг 9 удаа зохион байгуулж 325 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна.

- Эхний хагас жилийн байдлаар Хангарди зоогийн газрын өдрийн хоолны үйлчилгээг өдөрт 100-150 хүн авдаг байсан бол сүүлийн хагас жилийн байдлаар өдөрт 200-250 гаруй албан хаагч үйлчлүүлдэг болсон. Энэхүү мэдээлэл дээр үндэслээд нэгтгэн харвал хагас жилийн байдлаар өдрийн хоолны үйлчилгээ авч буй хүний тоо 7.8%-иар өссөн тоон үзүүлэлт гарч байсан.

➤ Зоогийн газрын үйл ажиллагааны шинэлэг ажлууд:

Засаг даргын Тамгын газрын цайны газрын хоолыг сэт хэлбэрээр сонголттой хоолтой гаргадаг болсон нь үйлчлүүлэгчдэд хүрсэн шинэлэг үйлчилгээ болсон.

Эмчилгээний дэглэм барьж байгаа ажилтан, албан хаагчдад зориулсан сувилалын хоолыг зоогийн газар, цайны газруудад нэвтрүүлэн ажиллалаа.

Тамгын газрын ажилчдад зориулан Эрүүл ажлын байр сэдэвт өдөрлөгийг Их эмчийн хамт зохион байгууллаа. Тус арга хэмжээ тухайн хүний биеийн ерөнхий байдлыг үзэж оношлоод бие мах бодид тохирсон эрүүл, сувиллын хоолоор үйлчлэх онцлогтой арга хэмжээ байлаа. Арга хэмжээний үеэр авсан санал асуулгын дүнгээр 100% үйлчлүүлэгийн таашаалд нийцсэн арга хэмжээ болсон нь харагдаж байлаа.



Зураг 48. Сувилалын хоол

Үйлчлүүлэгчдийг татах зорилгоор Хангарди зоогийн газарт “Өглөөний цайг өөртөө” сэдэвт өглөөний цайны өдөрлөгийг зохион байгуулсан. Энэнхүү арга хэмжээнд нийт 100 гаруй оролцож үр дүнг тооцох санал асуулгаар сөрөг санал илгээсэн санал огт байхгүйн дээр ийм үйлчилгээг байнга авахыг хүссэн санал нь 70% байлаа. Үүнтэй уялдуулаад сүүлийн хагас жилд Хангарди ордны зоогийн газарт Кофе шоп нээн ажиллуулж, кофе шопын үйл ажиллагааг өглөөний цайтай уялдуулсан нь үйлчлүүлэгчдийн талархалыг хүлээсэн ажил болж чадсан.



*Зураг 49. Кофе шоп*

Зоогийн газруудын үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор “Ерөнхий тогоочийн долоо” хоног аяныг зоогийн газар, цайны газруудад 21 хоногийн хугацаанд зохион байгуулсан бөгөөд аяны хүрээнд зоогийн газрын үйчлүүлэгчдийн тоо 11%-иар өссөн дүнтэй байна.

➤ Тоног төхөөрөмжийн шинэчлэлт:

Сэт хоолны таваг 50ш, эрүүл ахуйн стандартад нийцсэн цайны шилэн аяга 200ш, 2 дугаар хоолны таваг 108 ширхэгийг тус тус шинэчилсэн.

Хоол үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааг хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй, чанар, стандартын дагуу зохих төвшинд хүргэх, боловсруулалтын үйл ажиллагааг сайжруулах 3,9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн.

Зоогийн газрын үйл ажиллагаанд бэлэн мөнгөний пос машиныг байрлуулсан.

Хангарди зоогийн газрын заалны 120 хүний ширээ сандлыг бүрэн шинэчилж, сандлын давцанд зориулалтын зөөлөвч хийлгэж тохижилтыг сайжруулав.



*Зураг 50. Шинэ ширээ, сандал*

## ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

### 4.1 Үйл ажиллагааны ил тод байдал

Байгууллагын эрхэм зорилго, зорилт болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм журам, дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг тухай бүр нь байгууллагын мэдээллийн самбар болон вэб сайтад нээлттэйгээр мэдээлэн ажиллаж байна.

[www.khangardi.mn](http://www.khangardi.mn) вэб сайт:

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд болон ажилтан албан хаагчдад сурталчилах, ил тод байлгах, танин мэдүүлэх зорилгоор [www.khangardi.mn](http://www.khangardi.mn) вэб сайтыг ажиллуулсаар ирсэн бөгөөд газрын зүгээс зохион байгуулсан болон дотоод үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухайд нь байршуулж байна.

Тайлант хугацаанд сайтад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 30 мэдээ, мэдээллийг тогтмол байршуулж, 20 удаагийн ажлын байрны сул орон тоог тухай бүр нь нийтэд зарлаж ажилласан.

Мөн байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг ил тод байдлын үндсэн 4 чиглэлээр [www.khangardi.mn](http://www.khangardi.mn) сайтад нээлттэйгээр байршуулан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар манай байгууллагын [www.khangardi.mn](http://www.khangardi.mn) цахим хуудсанд 680 үйлчлүүлэгч хандалттай байна.

Мэдээллийн самбарын ажиллагаа:

Байгууллагад шилэн дансны мэдээллийн самбарыг байршуулан

- Үйл ажиллагааны талаар мэдээлэл
- Төсөв, санхүүгийн ил тод байдал
- Хүний нөөцийн ил тод байдал
- Хяналт шалгалтын мэдээлэл

чиглэлээр мэдээ, мэдээллээр цаг тухайд нь ханган ажиллаж байна.



Зураг 51. Мэдээллийн самбар

Авилга, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх:

Тус газрын 2018 онд хэрэгжүүлэх авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийтийн албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг батлагдсан хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлсэн.

Авилгын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарч буй мэдүүлэг гаргагч 11 албан тушаалтны 2017 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд шинэчилэн гаргасан ба ХАСХОМ-1 тайланг 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 74 дүгээр албан бичгээр НЗДТГ-ын ТЗУХ-д хүргүүлсэн. Мөн тайлант хугацаанд 8 албан хаагч шинээр нэмэгдэн ХАСХОМ-ийг мэдүүлж хугацаанд нь баталгаажуулсан.

#### **4.2 Хүний нөөцийн бодлогын ил тод байдал**

Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгууллагын [www.khangardi.mn](http://www.khangardi.mn), [www.unegui.mn](http://www.unegui.mn) сайт болон дүүргүүдийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд ажлын байрны захиалга өгч сул орон тоог нээлттэй зарлаж хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг ханган ажиллаж байна. Мөн “Таныг сонсьё” аяны хүрээнд сул орон тооныг зарыг нээлттэйгээр зарлаж, сонирхсон иргэдийн асуултад хариулт өгч ажилласан. Дүүргүүдийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдээс ирүүлсэн зуучлалын мэдэгдэл, сайтын 27 удаагийн зараар 136 хүн материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн ба анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж, нийт 86 хүнийг шинээр ажилд томилсон.

Мөн НҮГ-ын хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрх зүйн акт баримтуудыг [www.khangardi.mn](http://www.khangardi.mn) сайтад байршуулан ажиллалаа.

#### **4.3 Төсөв, санхүүгийн ил тод байдал**

2018 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, хугацаанд нь НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн татварын газарт хүргүүлсэн ба төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, шилэн данс вэб сайтад 3 төрлийн тайланг, мөн байгууллагын мэдээллийн самбарт хугацаанд нь сар бүр байршуулан ажилласан

#### **4.4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал**

Бараа, ажил үйлчилгээ худалдан авагчийг сонгон шалгаруулах баримт бичиг, шалгарсан байгууллага, хийх ажил, зарцуулах хөрөнгө, гүйцэтгэлийн хугацаа зэрэг шаардлагатай мэдээллүүдийг нээлттэй мэдээлж ажилласан нь хөрөнгө оруулалтын ажилд иргэд, олон нийтээс хяналт тавих, тэдний оролцох боломжийг бий болгож, захиалагч, гүйцэтгэгч, ашиглагч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хөрөнгийг үр ашигтай зарцуулж ажлын чанарт ахиц гаргахад ач холбогдолтой ажил боллоо. Худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог газрын даргын 2018 оны А/23 дугаар тушаалаар байгуулж, сонгон шалгаруулалтыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу явуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, тайланг сар бүрийн 01-ний өдрийн дотор Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэн ажиллаж ирсэн.

## ТАВ. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

Үндэсний сэтгүүл зүйн 105 жил, Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр “Хараат бус сэтгүүл зүй” үндэсний форумыг 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Соёлын төв өргөөнд зохион байгууллаа. Үйл ажиллагааны үеэр 1000 сэтгүүлчийн цайны завсарлагыг манай хамт олон амжилттай зохион байгуулсан.



Зураг 52. “1000 сэтгүүлчийн форум”-ын цай завсарлагааны үеэр

Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны даргын баталсан “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээний хүрээнд батлагдсан хуваарийн дагуу Туул голын эрэг орчмыг цэвэрлэж, 123 шуудай хог, хаягдлыг цуглуулсан.



Зураг 53. “Их цэвэрлэгээний 90 минут” арга хэмжээний үеэр

2018 оны 6 дугаар сарын 18 ны өдөр Зүүн хойт Азийн хотуудын дарга нарын уулзалт боллоо. Уг арга хэмжээнд ННҮГ-ын Хангарид ордны Зоогийн газар нь “Чингисийн хүрээ” жуулчны баазад зохион байгуулагдсан “Бэсрэг наадмын” асарын үйлчилгээнд хоёр тогооч, найман зөөгч нийт арван таван хүний бүрэлдэхүүтэй, 2 их асар, 4 бага асарт гадаад, дотоодын 80 орчим төлөөлөгчдөд үндэсний хэв шинжийг илтгэсэн катерингийн үйлчилгээг үзүүллээ.



*Зураг 54. Бэсрэг наадмын үеэр*

2018 оны 07 дугаар сарын 10, 12, 13-ны өдрүүдэд Үндэсний их баяр наадмын зоогийн үйлчилгээнд ННҮГ-ын зоогийн газар нь төв цэнгэлдэх хүрээлэн болон Хүй долоон хутагт 340 орчим хүнд 12 нэр төрлийн зоогоор тус тус үйлчилсэн.



*Зураг 55. Үндэсний их баяр наадмын зоогийн үйлчилгээний үеэр*

2018 оны 8 дугаар сарын 4, 5-ны өдрүүдэд “Даншиг Наадам – Хүрээ Цам 2018” наадам арга хэмжээнд долоон тогооч, хоёр бэлтгэгч, хоёр угаагч, арван гурван зөөгч, нэг их эмч зэрэг нийт 35 хүний бүрэлдэхүүнтэй Даншиг наадмыг зохион байгуулах комиссын гишүүд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Засаг Даргын орлогч, Нийслэлийн харъяа агентлагуудын дарга, ажлын хэсгийнхэн болон бусад зочдод зоогийн үйлчилгээг үзүүллээ.



*Зураг 56. “Даншиг Наадам – Хүрээ Цам 2018”-ын зоогийн үйлчилгээний үеэр*

2018 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Өвөрхангай аймгийн Бүрд сумын Ширээт цагаан нуур багийн нутагт Нийслэлийн анхны шав тавьсан газар хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ болж өнгөрсөн. Арга хэмжээнд Нийтлэг үйлчилгээний газар нь таван





тогооч туслах тогооч нэг, угаагч нэг, зөөгч дөрөв нийт 23 хүний бүрэлдэхүүнтэй 15 нэр төрлийн зоогоор 180 гаруй зочдод үйлчилсэн.



*Зураг 57. Нийслэлийн анхны шав тавьсан газарт хүндэтгэл үзүүлэх ажиллагааны үйлчилгээний үеэр*

Эдгээр Нийслэл, төр захиргааны байгууллагаас зохион байгуулагдсан арга хэмжээнүүдэд зориулагдсан гэр, асар, майхан барих, буулгах, зөөвөрлөх ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэлээ.



*Зураг 58. Гэр асар майхан барих, буулгах, зөөвөрлөх ажлын явц*

## **ЗУРГАА. ДҮГНЭЛТ**

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2018 оныг “Иргэдийн-оролцоотой амьдрах орчныг сайжруулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан бодит ажил хэрэг болгоход тайлант оныхоо үйл ажиллагааг чиглүүлэн ажилласан бөгөөд нутгийн захиргааны байгууллага, түүний төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэн тэднээс гаргасан аливаа санал хүсэлтийг тухай бүр нь шийдвэрлэн ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний 32 арга хэмжээ, 2 тусгай захиалгат бүтээгдэхүүнийг бүрэн нийлүүллээ.

Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, захирамж, албан даалгаврын хүрээнд хамааралтай заалт, дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган, олон шинэлэг ажлуудыг хэрэгжүүлж, байгууллагын ил тод байдал, төсөв санхүүгийн сахилга батыг ханган ажиллалаа.

Нийтлэг үйлчилгээний газар нь ажилтан, албан хаагчдынхаа нийгмийн асуудал, сурч боловсрох, тэдний ажиллах нөхцөл боломжийг сайжруулахад анхааран, 2018 онд төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэн ажиллаж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, үйл ажиллагаагаа бүрэн хангалттай хэрэгжүүлсэн.

Ирэх онд ололт амжилтаа бататган, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэн үйлчилгээний ажлын чанарыг сайжруулж, дэвшилтэт хэлбэрийг сонгон, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, хүний нөөцийг мэрэгшүүлэх, чадавхижуулах зорилт тавин идэвх санаачилгатай, үр бүтээлтэй, ил тод байдлыг эрхэмлэн ажиллана.

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ